



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 06 сарын 26 өдөр

Дугаар А/104

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн 28 дугаар хорооны  
“Ерөөл буян оршихуй” өрхийн эрүүл  
мэндийн төвийн эргэлтийн бус  
хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн хурлын шийдвэрийг дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 5,456,900 /таван сая дөрвөн зуун тавин зургаан мянга есөн зуу/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээсээ хасахыг Баянзүрх дүүргийн “Ерөөл буян оршихуй” өрхийн эрүүл мэндийн төв /Р.Бурмаа/-д зөвшөөрсүгэй.


2. Данснаас хасагдаж буй хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Баянзүрх дүүргийн “Ерөөл буян оршихуй” өрхийн эрүүл мэндийн төв /Р.Бурмаа/-д үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /М.Энхболд/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ  Н.ОДНАСАН



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын  
газрын даргын 2019 оны 06 сарын  
26 өдрийн А/184 дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн Ерөөл буян оршихуй ӨЭМТ

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	ЭБХХХКомиссын хурлын шийдвэр
<b>Машин тоног төхөөрөмж</b>									
1	Суурин компьютер	7 жил	ш	3	782,000.00	2,346,000.00	2,346,000.00	-	татах
2	Суурин компьютер	7 жил	ш	1	782,000.00	782,000.00	782,000.00	-	татах
3	Суурин компьютер	5 жил	ш	1	830,000.00	830,000.00	830,000.00	-	татах
4	Зөөврийн компьютер	7 жил	ш	1	1,159,000.00	1,159,000.00	1,159,000.00	-	татах
5	Угаалгын машин	7 жил	ш	1	195,000.00	195,000.00	195,000.00	-	татах
<b>Машин тоног төхөөрөмжийн дүн</b>				<b>7</b>	<b>3,748,000.00</b>	<b>5,312,000.00</b>	<b>5,312,000.00</b>		
<b>Тавилга эд хогшил</b>									
1	Ус буцалгагч	4 жил	ш	1	30,000.00	30,000.00	30,000.00	-	татах
2	Ус буцалгагч	4 жил	ш	1	114,900.00	114,900.00	114,900.00	-	татах
<b>Тавилга эд хогшилын дүн</b>				<b>2</b>	<b>144,900.00</b>	<b>144,900.00</b>	<b>144,900.00</b>		
<b>Нийт данснаас хасах хөрөнгийн дүн</b>						<b>5,456,900.00</b>	<b>5,456,900.00</b>		
Үүнээс: Худалдах хөрөнгө									
Актлах хөрөнгө									
Татан төвлөрүүлэх хөрөнгө						<b>5,456,900.00</b>			
Худалдсанаас олох орлого									
НӨХГ-т төвлөрүүлэх /30 %/									